

ХИЛ ХАМГААЛАХ УРЛАГТ ХАНДАХ ОРЧИН ҮЕИЙН ХАНДЛАГА

П.ДАШ

ГСҮХ-ийн эрдмийн зөвлөлийн гишүүн, батлан хамгаалах аюулгүй байдлын чиглэлээр докторын зэрэг хамгаалуулах зөвлөлийн гишүүн, доктор (Ph.D), профессор

Л.МӨНХДЭМБЭРЭЛ

Шихихутаг их сургуулийн дэд захирал, хууль зүйн ухааны магистр

Хураангуй

Хил хамгаалах урлагийг цэргийн урлагийн нэгэн адилаар тодорхойлж байсан үе ч бий, хил судлалын үүднээс арай өөрөөр тодорхойлж байсан ч үе бий. Өнөөдөр шинжлэх ухаан, технологийн дэвшил, хил хамгаалалтын бодлогод гарсан өөрчлөлт хилийн аюулгүй байдалд хандах хандлага зэргээс үндэслэн хил хамгаалах урлагийг илүү өргөн хүрээнд харж, судлах зүйл, хамрах хүрээ, мөн чанарт нэлээд өөрчлөлт орох хандлагатай болсон байна. Үүнтэй холбоотойгоор хил хамгаалах урлагт хандах орчин үеийн хандлагын мөн чанар, хил хамгаалах урлагийн бүрэлдэхүүн хэсэг, ялангуяа хараахан нэгдсэн нэг ойлголтод хүрч чадаагүй байгаа хилийн аюулгүй байдал зэрэг асуудлыг авч үзсэн болно. Хил хамгаалах урлагийн орчин үеийн хандлагыг судлахын тулд хууль, тогтоомж, олон улсын гэрээ, хэлэлцээр зэрэг эх сурвалжид баримт бичгийн шинжилгээ хийж, түүхэн судалгааны арга,

харьцуулалт, социологийн судалгааны аргуудыг ашиглав. Энэхүү судалгааны үр дүнд хил хамгаалах урлагийн уламжлалт ойлголт дээр “ухаалаг хил”, “хил орчмын интеграцчилал”, “хил дамнасан гэмт хэргээс урьдчилан сэргийлэх” зэрэг цоо шинэ болон тодотгосон ойлголтууд гарч ирж байгаа нь хил хамгаалах урлагийн орчин үеийн хандлагыг тодорхойлох нэг гол үзүүлэлт болж байгааг олж тогтоов.

Түлхүүр үг: хил хамгаалах арга зүй, ухаалаг хил, хил орчмын интеграцчилал, кибер хил хамгаалалт, дасан зохицох арга зүй.

Abstract

There was a time when border protection art was defined as a military art, and there was a time when it was defined differently from the perspective of border studies. Today, based on scientific and technological progress, changes in border protection policies, and the approach to border security, border protection art has become more widely viewed and studied, with a tendency to change significantly in its scope and nature. In this regard, the nature of the modern approach to border protection art, the components of border protection art, especially border security, which has not yet reached a unified understanding, is discussed. In order to study the modern approach to border protection art, document analysis was conducted on sources such as laws, regulations, international treaties and agreements, and historical research methods, comparisons, and sociological research methods were used. As a result of this study, it was

found that completely new and distinct concepts such as “smart border”, “border integration”, and “prevention of cross-border crime” are emerging in the traditional understanding of border protection art, which is a key indicator of the modern approach to border protection art.

Keywords: border protection methodology, smart border, border integration, cyber border protection, adaptive methodology.

Удиртгал

Хил судлалын шинжлэх ухааны судлах зүйл нь улсын хилийн түүх судлал, хил хамгаалах урлаг, хил хамгаалах эрх зүй байдаг бөгөөд эдгээрээс хамгийн динамик хөгжилтэй, өргөн хүрээ хамарсан асуудал нь хил хамгаалах урлаг байдаг.

Дэлхий нийтээр шинжлэх ухаан техникийн дэвшил, олон улсын харилцаа, олон улсын хэмжээнд сүүлийн үед түгээмэл гарах болсон улсын хилийн халдашгүй дархан байдалд сөргөөр нөлөөлөх үйл явдлууд, тэдгээрийн улмаар улсын хил хамгаалах бодлогод гарч байгаа өөрчлөлт, цаашдын төлөв, хандлага хил хамгаалах урлагт хүчтэй нөлөө үзүүлж байгаагаас хил хамгаалах урлагийн судалгаанд бодитоор хандахыг шаардах боллоо. Энэ нь нэг талаар хил судлалыг хөгжүүлэх хэрэгцээ, улсын хилийн хамгаалалтыг боловсронгуй болгох шаардлага, хил хамгаалалтын хуучин арга барилаар шинэ нөхцөл байдалд хандах боломжгүй болсон байдал зэргээр илэрч байна. Энэхүү нөхцөл байдал нь олон улсын болон дотоодын нөхцөл байдалд зохицон

ажиллах явдал тулгамдсан асуудал болсныг харуулж байна. Иймд дараах асуудлыг судлах зорилгыг тавьсан болно.

Зорилго:

Улсын хилийн халдашгүй дархан байдалд үзүүлж байгаа эерэг, сөрөг нөлөө (гадаад, дотоод цагийн байдал), олон улсад хүлээн зөвшөөрсөн хил хамгаалалтын тухай ойлголт, хил хамгаалалтад тавигдаж байгаа шаардлага, баримталж байгаа бодлого, хил хамгаалалтын хүч хэрэгсэл, боломж, бололцоо зэрэгт тулгуурлан хил хамгаалах урлагийн орчин үеийн хандлагыг тодорхойлох. Уг зорилгодоо хүрэхийн тулд дараах зорилтуудын дэвшүүлээ.

Зорилт:

1. Хил хамгаалах урлагт нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг тодорхойлох.

2. Хил хамгаалах урлагийн тухай ойлголт түүний мөн чанарыг тодорхойлох.

3. Хил хамгаалах урлагийн орчин үеийн хандлагыг тодорхойлох.

Судалгааны арга зүй, арга

Хил хамгаалах урлаг нь өөр хоорондоо нягт уялдаа холбоотой, бие биедээ харилцан үйлчилж байдаг элементүүдээс бүрдсэн, гаднын нөлөөнд оршиж, эргээд гадаад орчиндоо нөлөөлж байдаг бүхэл систем болохын хувьд түүнийг судлахын тулд системийн хандлагыг хэрэглэхийг шаарддаг ухагдахуун юм. Иймд хил хамгаалах урлагт хандах орчин үеийн хандлагыг судлахын тулд системийн хандлагыг ашигласны

дээр дараах аргуудыг хэрэглэн судалгаа хийлээ. Тухайлбал,

Улсын хилийг хамгаалах бодлогын баримт бичгүүд, олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль, тогтоомжууд зэрэг эх сурвалжийг судлан задлан шинжлэх баримтын шинжилгээний арга, хил хамгаалах урлаг, хилийн аюулгүй байдлын түүхэн хөгжил, өөрчлөлт, туршлага, сургамжийг судлах түүхэн судалгааны арга, бусад улс орнуудын хил хамгаалах арга барил, хил хамгаалалт болон хилийн аюулгүй байдлыг хангах тогтолцоог өөрийн орны хил хамгаалалт, хилийн аюулгүй байдлыг хангаж байгаа байдалтай харьцуулан судлах харьцуулалтын арга, хил орчмын оршин суугчид, хил хамгаалах байгууллагын алба хаагчидтай ярилцах, тэдний санал бодлыг сонсох, туршлагыг судлах социологийн судалгааны арга, хилийн аюулгүй байдалд учирч болзошгүй эрсдэлүүдийг тодорхойлж, шинжлэх, үнэлэх эрсдэлийн үнэлгээний арга зэрэг аргуудыг тус тус ашиглалаа.

Судалгааны ажлын үр дүн

Хил хамгаалах урлагт нөлөөлж байгаа хүчин зүйлүүд

Улсын хил хамгаалалтад олон хүчин зүйл нөлөөлдөг болох нь судалгаанаас харагдлаа.

Улсын хил хамгаалалт болон хил хамгаалах урлагт нөлөөлж байгаа хүчин зүйлүүдийг эерэг, сөргөөр нь ангилж үзвэл,
Сөрөг хүчин зүйлүүд:

Олон улсын харилцаа нээлттэй болохын хэрээр зорчигч тээврийн хөдөлгөөн эрс нэмэгдэж хилийн боомтын ачаалал нэмэгдэж, тэнд

аюулгүй байдлыг хангах асуудал улам бүр хурцаар тавигдах боллоо.

Дэлхий нийтээр эдийн засгийн зах зээлийн харилцаанд орсон явдал ил, далд эдийн засгийг эрчимтэй хөгжүүлж байгааг дагалдаад зэвсэг, хар тамхи, мансууруулах бодис, хүн (ялангуяа хүүхэд, эмэгтэйчүүд)-ий наймаа зэрэг хууль бус наймаа улсын хил дамнан явагдах боллоо.

Шашин хоорондын зөрчлөөс илүү байгалийн баялагт шунасан, түүнийгээ хэрэгжүүлэхийн тулд шашин хоорондын, үндэстэн хоорондын, үзэл суртлын, үзэл бодлын талцал, тэмцэл, хагарал, ялгарлыг ашиглан үймээн самуун, террорист ажиллагаа, дайн тулаанд өдөөн турхирч түүний улмаар жижиг буурай орнуудын тусгаар тогтнол, газар нутгийн бүрэн бүтэн байдал, хил хязгаарын халдашгүй дархан байдал алдагдаж, хил дамнасан дүрвэлт, цагаачлал эрс нэмэгдлээ.

Хөрөнгө, мөнгөнд хэт шунасан, шунахай сэтгэл хүний мөн чанар, зан төлөвт ихээр нөлөөлж, жирийн иргэд, алба хаагчид, албан тушаалтнууд авлига, хээл хахуульд автаж, бусдын байтугай өөрийн амь насыг ч юман чинээ бодохоо больж, эх орон, элгэн садан, амь нас, эрүүл мэндээ хайрлах сэтгэл улам бүр алсарч, аливаа ажил, албан тушаалыг зөвхөн “мөнгө” гэж харах нь улам улмаар нэмэгдсээр байна.

Энэ бүхэнд даяаршил, хүний эрх, эрх чөлөөний тухай буруу ойлголт ихээр нөлөөлж эх оронч үзлийг явцуу үзэл, үүрэг, хариуцлагыг дарамт, шахалт, дур зоргоор аашлах, хууль дүрэм

зөрчихийг ардчилал гэж ойлгуулах, ойлгох явдал газар авч, эх орон, тусгаар тогтнол, ардчилал, хүний эрх, эрх чөлөө гэдэг үгийг зөвхөн ард түмэнд таалагдахын төлөө хэлдэг үг болгон ашиглаж байгаагаас эх орон, тусгаар тогтнолоо хамгаалах, хүмүүнлэг, энэрэнгүй, ардчилсан нийгэм байгуулах сэтгэл, зүрхтэй хүмүүс цөөрсөөр байна.

Эерэг хүчин зүйлүүд:

Шинжлэх ухаан, техник, технологи хөгжихийн хэрээр улсын хилийн хамгаалалтад хүнийг орлох ухаалаг технологиуд нэвтэрсээр байна. Тухайлбал,

- Улсын хилийг камерын хяналтад авах, нисэгчгүй нисэх хэрэгсэл ашиглан хилийн цагийн байдалд хяналт тавих, хилийн цагийн байдлын мэдээллийг тухайн цагт нь авах боломж бүрдэж байна.

- Газар, ус, агаарт хилийн зөрчлийг илрүүлэх техник, технологийн шийдлүүд бий боллоо.

- Бичиг баримтын хуурмаглал төдийгүй царай зүс, биеийн хэлбэр, галбираа өөрчилсөн зэрэг биеийн хуурмаглалыг илрүүлэх боломжтой боллоо.

Мэдээллийн сүлжээ, тогтолцоо цаг хугацаа, орон зай үл хамаарах хэмжээнд хөгжиж байна.

Хиймэл оюун ухаан, робот техникийн хаа сайгүй хэрэглэх боломжтой боллоо.

Ямар ч их хэмжээтэй мэдээллийг хормын дотор боловсруулж, хамгийн ухаалаг шийдвэр гаргах боломж бүрдээд байна.

Хөрш орнуудтайгаа стратегийн түвшинд харилцаж, хамтран

ажиллаж байгаа нь улсын хилийг хамтран хамгаалах, харилцан туслалцах өргөн боломжийг олгож байна.

Улсын хил хамгаалалтын материаллаг бааз улам бүр бэхжиж, ажиллаж амьдрах орчин улам бүр сайжирч байна.

Зам харилцаа, холбоо сүлжээ сайжирч хилд алба хаах нь алслагдсан бөглүү газар, бүхнээс тусгаарлагдсан байдалд байдаг гэсэн ойлголт алхам тутамд алсарч байна.

Энэ мэт эерэг, сөргөөр нөлөөлж байгаа хүчин зүйлүүд нь улсын хил хамгаалалтад тэр чанараараа нөлөөлж хил хамгаалах урлагийн цаашдын хандлагыг тодорхойлж байна.

Хил хамгаалах урлаг: Үндсэн ойлголт, мөн чанар

Хил хамгаалах урлаг гэдэг нь улсын хилийн халдашгүй дархан байдал, аюулгүй байдлыг хангахын тулд олон талт стратеги, тактик, арга барилыг уялдуулан хэрэгжүүлэх цогц ухаан юм. Энэ нь цэрэг, дипломат, мэдээлэл, технологи, дэд бүтэц, эрх зүйн зохицуулалт зэрэг олон хүчин зүйл дээр тулгуурладаг.

Үүнээс хил хамгаалах урлагт хил хамгаалалт, хилийн аюулгүй байдал гэсэн хоёр том ухагдахууныг авч үзэх шаардлагатай болох нь харагдаж байна.

Хил хамгаалалт

Хил хамгаалалтыг үндсэнд нь хилийн зөрчил будилаанаас **урьдчилан сэргийлэх арга хэмжээ, хилийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ, дасан**

зохицох арга зүй гэсэн гурван үндсэн чиглэлд хуваан үзэж болно.

Улсын хилийн зөрчил, будлианаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ

- Хилийн тагнуул, мэдээллийн системийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх: Хилийн бүсэд тагнуулын ажиглалт, тандалт, мэдээлэл цуглуулах, тэдгээрийг боловсруулах, үр дүнг улсын хил хамгаалалтад ашиглах нэгдсэн тогтолцоо бүрдүүлэх,

- Улсын хилийг инженерийн талаар төхөөрөмжилж, ашиглалтын нарийн горим тогтоох: Торон саад, бэхлэлт, төрөл бүрийн хяналтын байр, хяналтын цэгүүдийг байгуулж, ашиглалтын нарийн горим бүхий нэгдсэн систем бүрдүүлэх.

- Хилийн орчны хамтын ажиллагаа: Орон нутгийн иргэдийг хил хамгаалалтад оролцуулах, хууль бус үйлдэлтэй тэмцэхэд хамтарсан ажиллагаа явуулах.

- Хил орчмын дипломат ажиллагаа: Хөрш орнуудтай аюулгүй байдлын гэрээ, хамтын ажиллагааны санамж бичиг байгуулж мөрдөх.

Хилийн асуудлыг шийдвэрлэх арга хэмжээ

- Хууль бус үйлдлийг таслан зогсоох: Хууль бус хил нэвтрэлт, зэвсэгт халдлагад цаг алдалгүй хариу өгөх.

- Хил дээрх зөрчлийг түргэн шийдвэрлэх: Хилийн маргаан, зөрчлийг дипломат болон цэргийн түвшинд шийдвэрлэх тактик.

- Хамтын ажиллагааны тогтолцоо: Цагдаа, тагнуул, зэвсэгт

хүчинтэй уялдаа холбоотой ажиллах.

Дасан зохицох арга зүй

- Улсын хилийг цагийн байдалд зохицуулан хамгаалах

- Цаг уур, газар зүйн нөхцөлд тохируулан ажиллах: Цөл, уулын бүс, усан хил зэрэгт тохирсон хамгаалалтын арга хэмжээг хэрэгжүүлэх.

- Техник, технологийн хөгжил, дэвшлийг ашиглах: Дрон, хиймэл дагуулын тандалт, ухаалаг мэдрэгч суурилуулан хилийн хяналтыг сайжруулах.

- Орон нутгийн иргэдийг орон нутгийн байршлаар татан оролцуулах: Орон нутгийн мэдээгээр хил зөрчих үйлдлийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх.

Улсын хил хамгаалалтыг төрөлжүүлэн авч үзэх нь хил хамгаалалтыг оновчтой зохион байгуулахад онцгой ач холбогдолтой байдаг. Тухайлбал,

Хилийн цагийн байдлыг үнэлэх буюу хил хамгаалалтад учирч болох эрсдэлийг тодорхойлох, шинжлэх, үнэлэхэд ач холбогдолтой байдаг. Жишээ нь:

➤ Газрын хил: газрын хилийг хууль бус нэвтрэх, зэвсэгт халдлага үйлдэх, хүн амын шилжилт хөдөлгөөн, цагаачлал, дүрвэлт зэрэг эрсдэлийг тодорхойлох.

➤ Усны хил: Усан замаар хууль бус тээвэрлэлт, загас агнуурын зөрчил, усны бохирдол зэрэг асуудлыг үнэлэх.

➤ Агаарын хил: Агаарын орон зайд зөвшөөрөлгүй нислэг үйлдэх, тагнуулын үйл ажиллагаа явуулах, агаарын халдлага үйлдэгдэх зэрэг эрсдэлийг тодорхойлох.

➤ Кибер хил: Мэдээллийн сүлжээгээр дамжин явагдах кибер халдлага, мэдээллийн хулгай, цахим терроризм зэрэг эрсдэлийг үнэлэх гэх мэт.

Цагийн байдлын үнэлгээг үндэслэн хил хамгаалалтын төрөл тус бүр дээр тус тусын онцлогтой стратегийг боловсруулах боломжийг олгодог. Жишээ нь:

➤ Газрын хил: улсын хил дээр хяналтын цэгүүдийг байгуулах, улсын хилийг инженерийн талаар төхөөрөмжлөх боломжийг тодорхойлох, хилийн цэргийн хүчийг зохион байгуулах.

➤ Усны хил: Усан хил хамгаалах хөлөг онгоц, эргийн харуулын албыг ажиллуулах, усан замын хяналтыг сайжруулах.

➤ Агаарын хил: Радарын систем, агаарын харуулын нислэгүүдийг зохион байгуулах, агаарын довтолгооноос хамгаалах системийг хөгжүүлэх.

➤ Кибер хил: Мэдээллийн аюулгүй байдлын бодлого боловсруулах, сүлжээний хяналт, кибер халдлагаас хамгаалах технологийг нэвтрүүлэх гэх мэт.

Нөөцийг оновчтой хуваарилахад хил хамгаалалтын төрөл ач холбогдолтой байдаг. Тухайлбал, хил хамгаалалтын төрөл бүрд тохирсон хүч хэрэгсэл, зэвсэг техник, түүнд шаардагдах хөрөнгө, санхүүгийн эх үүсвэр хэрэгтэй бөгөөд тухайн төрлийн хил хамгаалалтад мэргэшсэн хүний нөөцийг бэлтгэж ажиллуулах, шаардлагатай техник тоног төхөөрөмжийг зохион бүтээх, сайжруулах, боловсронгуй болгох

зэрэг нь бие даасан салбарын чанартай болдог.

Хил хамгаалалтын төрлөөс шалтгаалаад харилцан ажиллагаа, хамтын ажиллагаа өөр өөрийн онцлогтой явагддаг. Хил хамгаалалтын тухайн төрөлд тохирсон янз бүрийн салбаруудын хооронд мэдээлэл солилцох, харилцан ажиллагаа болон хамтын ажиллагааг зохион байгуулах, тухайн төрлөөр нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах боломж бүрддэг.

Бодлого, эрх зүйн зохицуулалтын хувьд ч хил хамгаалалтын төрлөөр төрөлжүүлж, системчлэх шаардлагатай байдаг. Ийм учраас газрын, усны, агаарын, кибер хил хамгаалалтын дүрэм, заавар, журам тус тусдаа байх шаардлагатай болдог.

Иймээс улсын хил хамгаалалтын төрлийг дараах байдлаар ангилж болно:

Хил хамгаалалтын төрөл

1. Газрын хилийн хамгаалалт – Хуурай газрын хил дээр хамгаалалтын бэхлэлт, хилийн манаа, харуулын байр, инженерийн байгууламж ашиглах байдлаар хил хамгаалалтыг зохион байгуулж явуулна. Энэ нь газар орны буюу газар зүйн онцлогоос хамаараад дотроо уулын, өндөр уулын, говь цөлийн, тал хээрийн, ой тайгын гэх мэтээр ангилагдаж болно.

2. Усан хилийн хамгаалалт – Гол, нуур, далайн хил дээр хяналт тавих, усан онгоц, радарын систем ашиглах замаар хил хамгаалалт зохион байгуулагдана.

3. Агаарын хил хамгаалалт – Хиймэл дагуул, радар, нисгэгчгүй нисэх аппарат ашиглан хяналт тавих зэргээр агаар хил хамгаалалт зохион байгуулагдана.

4. Кибер хил хамгаалалт – Хил дээрх мэдээллийн аюулгүй байдлыг хангах, цахим халдлагаас хамгаалах арга хэмжээ авагдах ба компьютер, мэдээллийн хэрэгсэл, робот болон ухаалаг төхөөрөмж, хиймэл оюун ухаан ашиглан улсын хилийг хамгаалах ажиллагаа юм.

Улсын хилийн хамгаалалтад нөлөөлж байгаа гадаад, дотоод, эерэг, сөрөг хүчин зүйлүүдээс шалтгаалаад орчин үеийн хил хамгаалалтын чиг хандлага өөрчлөгдөж байна. Үүнд:

- Био таних технологи, ухаалаг камер, хиймэл оюун ашиглан хяналтын системийг сайжруулах Ухаалаг хил (Smart Border) гэсэн ойлголт,

- Олон улсын хамтын ажиллагааг бэхжүүлж, хууль бус наймаа, зэвсгийн худалдаа, хүний наймаатай тэмцэх хил дамнасан терроризм, гэмт хэргээс сэргийлэх гэсэн хил хамгаалалтын бие даасан төрөл,

- Хөрш орнуудтай хил орчмын бүсийн хамтын ажиллагааг өргөжүүлж, зөрчил багасгах хил орчмын интеграцчилал гэсэн хил хамгаалалтын шинэ арга гарч ирж байна.

Үүнээс гадна Хилийн аюулгүй байдал нь хил хамгаалах урлагийн чухал бүрэлдэхүүн хэсэгт багтдаг.

Хилийн аюулгүй байдал

Хилийн аюулгүй байдал гэдэг нь улсын хилийн орон зайд гарч болзошгүй аюул, эрсдэлээс

урьдчилан сэргийлэх, тэдгээрийг илрүүлэх, хариу арга хэмжээ авах цогц үйл ажиллагааг хэлнэ. Энэ нь хил хамгаалах урлагийн үндсэн зорилго болох улсын хилийн халдашгүй дархан байдал, дотоод аюулгүй байдлыг хангах үйл явцтай нягт уялдаатай байдаг тул хилийн аюулгүй байдал нь хил хамгаалах урлагийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг нь болдог.

Хилийн аюулгүй байдлын хүрээнд дараах чиглэлүүд хамаарна:

1. Улс төр, эрх зүйн аюулгүй байдал. Үүнийг хангах хүрээнд:

- Улсын хилтэй холбоотой зөрчил маргаан үүсгэхгүй байх нөхцөл бүрдүүлэх.

- Олон улсын гэрээ, конвенцын хүрээнд хилийн халдашгүй байдлыг баталгаажуулах.

- Хилийн орон зайд улсын хилтэй холбоотой зохицуулалтыг хууль эрх зүйн хүрээнд сайжруулах.

2. Цэргийн аюулгүй байдал. Үүнийг хангах хүрээнд:

- Гаднын зэвсэгт халдлагаас сэргийлэх.

- Хилийн бүс, зурваст байнгын харуулын систем, хяналтын байгууламжийг бэхжүүлэх.

- Стратегийн байршилтай пост, хяналтын төвүүдийг байгуулах.

3. Эдийн засгийн аюулгүй байдал. Үүнийг хангах хүрээнд:

- Хил дамнасан хууль бус бараа, бүтээгдэхүүний наймааг таслан зогсоох (хар тамхи, зэвсэг, хүний наймаа).

- Хил орчимд хууль бус олборлолт, ашиглалт (худалдааны зөрчил, нөөц баялгийн хулгай) зэргийг илрүүлэх, таслан зогсоох.

- Эдийн засгийн тээвэр логистикийг хянаж зохицуулах.

4.Нийгмийн аюулгүй байдал. Энэ хүрээнд:

- Хил орчмын иргэдийн амьдрах орчныг хамгаалах.

- Хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдалд хохирол учруулах магадлалтай үйлдлийг (химийн бодис, биологийн халдварт өвчин) хянах.

- Хил орчмын бүсэд иргэдийн амь нас, эд хөрөнгийг хамгаалах.

5.Хууль бус үйл ажиллагаанаас хамгаалах. Энэ хүрээнд:

- Хилээр хууль бус нэвтрэх элдэв хөдөлгөөнөөс сэргийлэх (хүмүүсийн хууль бус шилжилт, дүрвэгсдийн урсгал).

- Терроризм, экстремизмийн нөлөөллийг хязгаарлах.

- Цахим орчинд хилийн аюулгүй байдлыг хангах (кибер халдлагаас хамгаалах).

6.Экологийн аюулгүй байдал. Үүнийг хангах хүрээнд:

- Хил орчмын байгалийн баялаг, экосистемийг хамгаалах.

- Химийн, цацраг идэвхт бодис улсын хилээр хууль бусаар нэвтрүүлэхээс урьдчилан сэргийлэх.

- Газар нутгийн доройтлоос сэргийлж, байгаль орчны тэнцвэрийг хадгалах.

7.Технологийн аюулгүй байдал. Үүнийг хангах хүрээнд:

- Хил хамгаалалтад өндөр технологи нэвтрүүлэх (дрон, хиймэл дагуул, ухаалаг камерууд).

- Хилийн хяналтын системийг кибер халдлага, гажилтаас хамгаалах.

- Тусгай зориулалтын тоног төхөөрөмж ашиглан аюулыг түргэн илрүүлэх, шийдвэрлэх.

Хилийн аюулгүй байдлыг хангахын тулд тодорхой ойлголтуудыг авч үзэх шаардлагатай. Энэ нь хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг хариуцлагыг хуваарилахад чухал ач холбогдолтой байдаг.

ОХУ болон хуучин ЗХУ-ын бүрэлдэхүүнд байсан ихэнх улсын хувьд хилийн аюулгүй байдлын хүрээнд пограничная сфера (хилийн аюулгүй байдлын хамрах хүрээ), пограничное пространство (хилийн аюулгүй байдлын хангах үйл ажиллагаа явуулж буй орон зай) гэсэн ойлголтууд байдаг бөгөөд түүнийгээ хилийн зурвас, хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэр гэж хуваасан нь онолын хувьд нэлээд тодорхой бүтэцтэй загвар гэж хэлж болно.

Монгол Улсын хувьд энэ ангиллыг шууд хуулбарлах нь оновчтой эсэхийг авч үзвэл, дараах хүчин зүйлсийг харгалзах шаардлагатай:

ОХУ-ын энэхүү бүтцийн давуу талууд

-Нарийвчилсан шатлалтай – Хилийн аюулгүй байдлын орон зайг тодорхой хуваах нь менежмент, удирдлагын хувьд илүү үр ашигтай байж болох талтай.

-Аюулгүй байдлын түвшний ялгаа гаргах боломжтой – Хилийн зурвас, хилийн бүс, хил орчмын нутаг дэвсгэрийг тусад нь ангилах нь аюулгүй байдлын эрсдэлийг зөв

үнэлж, шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг оновчтой хэрэгжүүлэх боломж бүрдүүлнэ.

-Хууль, эрх зүйн орчныг нарийн тодорхойлох боломжтой – Бүсчилсэн зохион байгуулалт нь тухайн нутаг дэвсгэрийн хязгаарлалт, зохицуулалт, тусгай дэглэмүүдийг нарийвчлахад тустай гэж үзэж болохоор байна.

Үүнийг Монгол орны нөхцөлд хэрэглэх боломж

Монгол Улс өөрийн газар зүйн онцлог, эрх зүйн орчин болон хил хамгаалах бодлогод нийцүүлэн ОХУ-ын энэхүү загварыг шууд бус, харин өөрийн нөхцөлд тохируулан хэрэглэж болох хувилбар бий. Үүнд:

“Хилийн аюулгүй байдлын хамрах хүрээ” (пограничная сфера) гэдэг ойлголтыг өргөтгөх боломжтой. Үүнд хил хамгаалах үйл ажиллагаа, тагнуулын ажил, гаалийн хяналт, цагаачлалын бодлого зэрэг хамаарч болно.

“Хил хамгаалах үйл ажиллагаа явуулж буй орон зай” (пограничное пространство)-г гурван түвшинд авч үзэх нь зохистой байж болох юм:

- Хилийн зурвас (Монголын хуулиар 100 м-ээс 10 км хүртэлх зайг хэлнэ)

- Хилийн бүс (Монголын хуулиар 25-30 км-т хамаарна)

- Хил орчмын нутаг дэвсгэр (аймаг, сумын түвшинд хамаарах, эдийн засаг, стратегийн ач холбогдолтой орон зай)

Монголын хилийн нөхцөл байдалд уялдуулж дотоодын хууль тогтоомжид тусгах, ОХУ болон бусад орны загварыг судалж,

Монгол Улсын Үндсэн хууль, Хилийн тухай хууль, Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай нийцүүлэн өөрчлөлт оруулах шаардлагатай.

Тулгарч болзошгүй хүндрэл, бэрхшээл

Газар зүйн нөхцөл байдал өөр: ОХУ-ын хил урт бөгөөд хилийн зурваст олон суурин, хотууд байдаг бол Монголд хүн ам сийрэг тул ийм нарийн зааг ялгахад бэрхшээлтэй байж магадгүй.

Эдийн засгийн хүчин зүйлс: Хилийн хамгаалалт, хяналтын зохион байгуулалтыг гурван түвшинд хэрэгжүүлэхэд санхүү, нөөцийн асуудал үүсэж болзошгүй.

Хууль, эрх зүйн зохицуулалт: Одоогийн хууль тогтоомжид шууд өөрчлөлт оруулах шаардлагатай болох тул хууль эрх зүйн шинэчлэл хийх хэрэгцээ үүснэ.

Хилийн аюулгүй байдлын онол арга зүйг Монгол орны нөхцөлд хөгжүүлэх боломж

Дээрх байдлаас үзэхэд ОХУ-ын хилийн аюулгүй байдлын тухай ойлголтууд нь онолын хувьд Монголд хэрэгжүүлэх боломжтой боловч, шууд хуулбарлах нь тийм ч таатай биш байж мэднэ. Харин хил хамгаалах бодлого, хуулийн зохицуулалт, газар зүйн байршил, эдийн засгийн хүчин чадлыг харгалзан Монголын нөхцөлд тохирсон хувилбарыг боловсруулах нь зүйтэй гэж үзэж байна.

Хилийн аюулгүй байдал нь стратеги, тактик, гүйцэтгэлийн түвшинд хэрэгждэг цогц ойлголт бөгөөд хил хамгаалалтад хүчтэй нөлөөлдөг. Үүнд:

а. Стратегийн түвшинд хилийн аюулгүй байдлын бодлогыг тодорхойлох, зохицуулах арга хэмжээ ордог.

Энэ түвшинд улс орны үндэсний аюулгүй байдлын хүрээнд хилийн аюулгүй байдлыг хангах урт хугацааны бодлогыг боловсруулах, хууль эрх зүйн орчныг тодорхойлох асуудал хамаарна.

б. Тактикийн түвшинд хилийн хамгаалалтын зохион байгуулалт, төлөвлөлт багтана.

Хилийн аюулгүй байдлыг хэрэгжүүлэх тактик, арга зүйг тодорхойлж, хилийн аюулгүй байдалтай холбоотой зөрчил гарсан үед түүнийг шуурхай зохицуулах төлөвлөлт, зохион байгуулалтын ажлын энэ түвшинд хийдэг.

с. Гүйцэтгэлийн түвшинд өдөр тутмын үйл ажиллагааг хэрэгжүүлэх арга хэмжээ хамаарна.

Хил хамгаалах байгууллагуудын өдөр тутмын үйл ажиллагааны удирдлага, зохион байгуулалт, хяналт, шинжилгээ, үүрэг, хариуцлага энэ түвшинд явагдах үйл ажиллагаа байх болно.

Хилийн аюулгүй байдлыг хангах субъектүүдийн эрх үүргийг түүний тогтолцооны түвшинд авч үзвэл:

1. Бодлогыг тодорхойлогч нь:

- Улс төрийн түвшинд Ерөнхийлөгч, Үндэсний аюулгүй байдлын зөвлөл, Засгийн газар улсын хэмжээнд хилийн аюулгүй байдлын бодлогыг тодорхойлж, үндэсний аюулгүй байдлын стратегийн нэг хэсэг болгон боловсруулдаг.

- Эрх зүйн орчныг бүрдүүлэгч нь парламент (Улсын Их Хурал) болон Засгийн газар байж, хилийн аюулгүй байдалтай холбоотой хууль, тогтоомж, дүрэм журмыг батална.

2. Өдөр тутмын удирдлагаар хангагч байгууллагууд нь хилийн асуудал эрхэлсэн төрийн байгууллагууд болох хил хамгаалах ерөнхий газар, хилийн цэрэг, цагдаагийн байгууллага, төрийн тусгай албад гэх мэт байгууллагууд байх бөгөөд хилийн аюулгүй байдлыг хангах бодлогыг хэрэгжүүлж, өдөр тутмын удирдлага, зохицуулалт, хяналт, шинжилгээгээр хангах үүрэгтэй.

3. Хэрэгжүүлэгч байгууллагууд нь хилийн цэрэг, шалган нэвтрүүлэх боомтын ажилтнууд, хяналтын бусад албад, гамшгаас хамгаалах орон нутгийн байгууллагууд байна. Эдгээр байгууллагууд хилийн аюулгүй байдлыг өдөр тутмын үйл ажиллагааны түвшинд хэрэгжүүлдэг.

Хилийн аюулгүй байдлыг хангах нь зөвхөн хил хамгаалах байгууллагуудаас гадна олон талт оролцоог шаарддаг. Үүнд:

- Цэрэг, цагдаа: Хилийн аюулгүй байдлыг баталгаажуулах.

- Тагнуул, мэдээллийн байгууллагууд: Аюулыг урьдчилан илрүүлэх.

- Засаг захиргааны байгууллагууд: Хил орчмын бүс нутгийн хөгжил, дэд бүтэц, нийгмийн хамгааллыг хангах.

- Иргэдийн оролцоо: Иргэд хууль сахих, мэдээлэл дамжуулах

замаар хилийн аюулгүй байдалд хувь нэмэр оруулдаг.

Хилийн аюулгүй байдлын бодлогыг нэгтгэн зангидаж, нэгдсэн удирдлагаар хангах байгууллага зайлшгүй шаардлагатай. Энэ нь хилийн аюулгүй байдлыг хангах олон талт үйл ажиллагааг уялдуулах, бодлогын хэрэгжилтийг үр дүнтэй хянах, хариуцлагыг тодорхой болгоход чухал үүрэгтэй байна. Хэрэв бодлого, үйл ажиллагаа нь салангид байдлаар хэрэгжвэл дараах хүндрэлүүд үүсэх магадлалтай:

- Бодлогын давхардал: Төрийн байгууллагууд өөр өөр чиглэлд, харилцан уялдаагүй ажиллах.

- Хариуцлага тодорхойгүй болох: Тухайн үйл ажиллагаа үр дүнгүй болоход аль байгууллага хариуцах нь тодорхойгүй.

- Нэгдсэн хяналт сулрах: Хил хамгаалалт, аюулгүй байдлын ажиллагаа системтэй хянагдахгүй, зохицуулалт алдагдах зэрэг хүндрэлүүд үүсэх магадлалтай юм.

Иймд **Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн бүтэц**-д хилийн аюулгүй байдлын асуудлыг дагнан хариуцсан нэгж, Засгийн газрын дэргэд Хилийн аюулгүй байдлын үндэсний зөвлөл байх шаардлагатай бөгөөд тэдгээрийн үүрэг нь:

1. Бодлогыг боловсруулах, хэрэгжилтийг хянах:

- Үндэсний хэмжээний хилийн аюулгүй байдлын бодлогыг боловсруулах, батлуулах.

- Хилийн аюулгүй байдлын талаарх эрх зүйн орчныг хянан сайжруулах.

2. Нэгдсэн удирдлага:

- Хил хамгаалалтын бүх байгууллагын үйл ажиллагааг уялдуулж, удирдлагаар хангах.

- Бүх түвшний (стратегий, тактик, гүйцэтгэл) төлөвлөгөөг нэгтгэх, батлах.

3. Хяналт-шинжилгээ:

- Хилийн бүсийн аюулгүй байдлын нөхцөл байдалд нэгдсэн үнэлгээ өгөх.

- Бодлогын хэрэгжилтэд хяналт тавьж, шаардлагатай тохиолдолд арга хэмжээ авах.

4. Олон улсын хамтын ажиллагаа:

- Хил орчмын аюулгүй байдлыг хангахад хөрш орнууд болон олон улсын байгууллагуудтай хамтран ажиллах.

Хилийн аюулгүй байдлыг хангах үйл ажиллагааг нэгдсэн удирдлагаар хангах үүрэгтэй ҮАБЗ болон Засгийн газрын байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг эрхлэн явуулах ажлын алба нь хил хамгаалах ерөнхий газар байж хилийн аюулгүй байдлыг хангах үүрэг бүхий байгууллагуудын үйл ажиллагааг уялдуулах зохицуулах, үндэсний зөвлөлөөс өгсөн үүргийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулж удирдлагаар хангана. Ингэснээр:

- Хилийн аюулгүй байдлын талаар баримтлах бодлого, үйл ажиллагааны уялдаа холбоог хангах,

- Хариуцлагыг тодорхой болгох,

• Бодлогын хэрэгжилтэд үр дүнтэй хяналт тавих гол үндэс болно.

Энэ бүгдээс үзэхэд хил хамгаалах урлаг нь улсын хилийн хамгаалалт, хилийн аюулгүй байдлын хангах үйл ажиллагааг хамарсан зөвхөн цэргийн ажиллагаа төдий зүйл биш, харин дипломат бодлого, технологи, эрх зүй, стратеги, орон нутгийн оролцоо зэрэг олон хүчин зүйлсийг уялдуулсан цогц системийг судлах ухаан юм гэсэн дүгнэлтийг хийж болно. Төр улс хил хамгаалалтын бодлогоо зөв тодорхойлж, стратегиа сайжруулснаар улсын хилийн хамгаалалтыг боловсронгуй болгож, улсын хилийн аюулгүй байдлыг хангах боломжтой гэсэн дүгнэлтэд хүрч байна.

Хэлэлцүүлэг

Хилийн аюулгүй байдлын талаар судалсан судалгаа, бичсэн өгүүлэл нэлээд их байдаг боловч хил хамгаалах урлагийн талаар бүтээл туурвилууд төдийлөн элбэг биш байна. Энэ нь хил хамгаалалтын стратеги, тактик, арга зүйтэй холбоотойгоор нууцлах явдал элбэг байдагтай холбоотойгоос гадна дагнан судалдаг судлаачид ховор байгаатай холбоотой биз. Бүр 1997, 1998 онд миний бичиж байсан “Хил хамгаалалтын онол” ном, “Хил хамгаалах урлагийн судлах нь улсын хил хамгаалалтыг боловсронгуй болгох үндэс мөн” ЭШӨ өнөөдөр хаана ч үзэгдэхээ больсон. Манай хилчдийн хийсэн судалгаанууд нууцын зэрэглэлтэй учраас шинжлэх ухааны эргэлтэд

төдийлөн орж чадахгүй байгаа зэрэг нь хил хамгаалах урлагийг хөгжүүлэхэд зохих хэмжээгээр сөрөг нөлөө үзүүлсээр байна. Иймд энэхүү судалгаагаараа хил хамгаалах урлагийн орчин үеийн хөгжлийн чиг хандлагыг нээлттэй тавьж байгаа билээ. Үүнд хил судлал болон хил хамгаалах урлагийн бүрэлдэхүүн хэсэг, түүнд нөлөөлж байгаа гадаад, дотоод хүчин зүйл, өрнөж байгаа цагийн байдал, геополитикийн өрнөл, шинжлэх ухаан, техник, технологийн дэвшлийн талаар судалж мэдсэн зүйлээ хуваалцаж байна. Энэхүү хэлэлцүүлгийн үр дүнд Монгол Улсын хил хамгаалах урлаг шинэ хэлбэр, агуулгаар баяжна гэдэгт итгэлтэй байна.

Дүгнэлт

Хил судлалын судлах зүйл нь улсын хилийн түүх судлал, хилийн аюулгүй байдал болон улсын хилийн хамгаалалтын стратеги, тактик, арга зүйг судалдаг хил хамгаалах урлаг, хил хамгаалалтын эрх зүйг судалдаг шинжлэх ухаан бөгөөд эдгээрээс хил хамгаалах урлагийг судлах нь өнөөгийн тулгамдсан асуудлын нэг болоод байна. Учир нь Олон улсын харилцааны нөхцөл байдал хурдтай өөрчлөгдөж, бүс нутгийн болон дэлхийн хэмжээний зөрчил, маргаан нэмэгдэж, улсын хилийн аюулгүй байдлыг хангах шинэ арга, стратегийг боловсруулах шаардлагыг бий болгож байгаа геополитикийн өөрчлөлтүүд, терроризм, хууль бус худалдаа, хүний наймаа, кибер халдлага зэрэг уламжлалт бус аюул заналууд нэмэгдэж, хил хамгаалалтын арга

барилыг шинэчлэх, сайжруулах хэрэгцээг үүсгэж байгаа шинэ төрлийн аюул заналхийлэл, дрон, хиймэл оюун ухаан, хяналтын дэвшилтэт системүүдийг үр ашигтай ашиглах, эсвэл тэдгээрээс хамгаалах арга замыг судлах шаардлагыг бий болгож байгаа технологийн дэвшил, хилийн аюулгүй байдалтай шууд холбоотой эдийн засаг, нийгмийн хөгжил, чөлөөт бүсийн үйл ажиллагаа бүхий хил орчмын бүс нутгийн хөгжил, хилчдийн хил хамгаалах үйл ажиллагааны үр нөлөө, үр дүнг бууруулж болзошгүй сэтгэл зүй, нийгмийн асуудлууд зэрэг нь улсын хилийн аюулгүй байдлыг хангах, улсын хилийг хамгаалах үйл ажиллагааг урьдын адил явуулах, хэвшмэл байдалд хадгалах боломжгүй болгож байгаа тул хил судлал, түүний дотор хил хамгаалах

урлагийг цаг үеийн байдалд тохируулан цаг алдалгүй боловсронгуй болгон хөгжүүлж байхыг шаардах боллоо.

Иймд хил хамгаалах урлагт хандах орчин үеийн хандлагыг тодорхойлох шаардлагатай бөгөөд үүний дагуу хилийн аюулгүй байдал, хил хамгаалалтын стратеги, тактик, үйл ажиллагааг боловсронгуй болгохын тулд энэхүү судалгааны үр дүнд тулгуурлан хилийн аюулгүй байдлыг хангах нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх, хил хамгаалалтын талаарх хэвшмэл ойлголтоо эргэн харж, хил хамгаалах стратеги, тактик, арга зүй, ухаалаг хил, кибер хил хамгаалалтад ихээхэн анхаарал хандуулах шаардлагатай болоод байна.

Ном зүй

1. Susan, F.Martin., Elizabeth Ferris. "The Law of the Border: Implications for Security and Sovereignty" Routledge. 2018.
2. David E. Lorey., Mallcolm Anderson., Frederick Baker. "Borders and Border Politics in a Globalizing World". SR Books. 2005.
3. "Border Security: Understanding Threats at the Borders" CRC Press. 2013.
4. Савин В.П. "Граница: история и современные вызовы" М.:2015.
5. ПРОБЛЕМЫ БЕЗОПАСНОСТИ НОВЫХ ГРАНИЦ РФ И ФОРМИРОВАНИЕ ПОГРАНИЧНОЙ ПОЛИТИКИ.
<http://www.obraforum.ru/book/paragraph23.htm>
6. "The Law of the Border: Implications for Security and Sovereignty"
7. Арвай.Ш., Наранжамц.Н., Муратхан.А., Нямдорж.Д., "Хил судлалын шинжлэх ухааны онол, практикийн зарим асуудал". УБ. 2016.
8. Арвай.Ш. "Үндэсний аюулгүй байдлын үүднээс хилийн аюулгүй байдлыг шинжлэх нь". УБ. 2018.
9. Арвай.Ш. Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам, УБ. 2018.
10. Ганболд.Ц. "Хилийн аюулгүй байдлаа хангаж буй гадаадын зарим орнуудын туршлага, сургамж", Хилийн аюулгүй байдалд тулгамдаж буй асуудал, шийдвэрлэх арга зам. УБ. 2018.